



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 4/2015

Чингис

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Буцалтгүй тусламж олгох /код 932/ журам"-ын 932.2.16, Цагдаагийн газрын дотоод журмын 10 дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргаар он удаан жил үр бүтээлтэй ажиллаж байсан бэлтгэл цагдаагийн хурандаа Д.Доржийн гэр бүлийн хүний эмчилгээний зардалд зориулж туслах аж ахуйгаас 1 /нэг/ үхэр буцалтгүй тусламжийн зориулалтаар олгосугай.
2. Буцалтгүй тусламжийн 1 /нэг/ үхрийг туслах аж ахуйгаас зарлагадахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.
3. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА



П.ОРОСТОГОО